



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/189

Булган сум

**Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон
шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/321 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Булган сумын “Эмийн цэцэглэн” өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны жилийн эцсийн үнэлгээ, 2025 оны 1 дүгээр улирлын гэрээний хэрэгжилт 70,07% буюу “Хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдэж гэрээ цуцалсантай холбоотой өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсугай.

2. Өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр сонгон шалгаруулах ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)
Б.Урангаваа (Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

Д.Отгонсүрэн (Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга)

С.Амар (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Ж.Гүндэгмаа (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)

Ц.Өсөхбаяр (Цоожид өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, өрхийн эмч, мэргэжилтнүүдийн холбооны төлөөлөл зөвшилцсөнөөр)

“Эмийн цэцэглэн” өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: М.Солонго (Аймгийн Засаг даргын тамгын газрын

6325011705

Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн
бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)

3.Өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр сонгон шалгаруулах арга хэмжээг
хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга
(М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР